



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 101

Чингис хот

“E-Mongolia болон Егр.e-mongolia”
системийг нэвтрүүлэх баг байгуулах

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын “а”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар тогтоолын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа нутгийн захиргааны байгууллагын харьяа байгууллагууд болон аравт, хэсгийн хэмжээнд “E-Mongolia болон Егр.e-mongolia” системийг шат дараатайгаар нэвтрүүлэх, системийн хэрэглээнд хяналт тавих эрх бүхий багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Багийн ахлагч: Ж.Гантулга

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Багийн орлогч дарга:

Ж.Энхбат

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Багийн гишүүд:

Ж.Саруултөгс

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн удирдлага, агентлаг хариуцсан мэргэжилтэн

П.Ариунбаатар

Боловсрол, соёл урлагийн газрын Статистик хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Д.Гантуул

Эрүүл мэндийн газрын Мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн

Э.Одхүү

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн

С.Баттөмөр

Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн

Л.Будсүрэн

Улсын бүртгэлийн хэлтсийн Мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн

У.Бат-Эрдэнэ

Татварын хэлтсийн Сүлжээ хариуцсан ажилтан

Д.Баасанжав

Нийгмийн даатгалын хэлтсийн Сургалт сурталчилгаа, сүлжээ зохицуулах мэргэжилтэн

231010030

2.

Э.Хэрлэн

Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын Мэдээлэл технологийн
мэргэжилтэн

2. "E-Mongolia болон Erp.e-mongolia" системийг нэвтрүүлэх багийн гишүүдийн ажил
үүргийн хуваарийг гаргаж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг багийн
ахлагч, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Ж.Гантулга/-д даалгасугай.

3. "E-Mongolia болон Erp.e-mongolia" системийг нэвтрүүлэх багт орсон албан
хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсрол соёл
урлагийн газар, Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Хүнс,
хөдөө аж ахуйн газар, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Газрын харилцаа,
барилга, хот байгуулалтын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. "E-Mongolia болон Erp.e-mongolia" системд байгууллагынхаа албан хаагчдыг
2021 оны 2 дугаар улиралд багтаан бүрэн нэвтрүүлж, хэрэглээнд хяналт тавьж ажиллахыг
аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа нутгийн захиргааны байгууллагын
харьяа байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

5. "E-Mongolia" системийн ач холбогдлыг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд
сурталчлан таниулж, аравт, хэсгийн гишүүдийн хэрэглээнд нэвтрүүлж ажиллахыг сумдын
Засаг дарга, хот, тосгоны Захирагч нарт тус тус үүрэг болгосугай.

6. Энэхүү захирамжийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг багийн
ахлагч, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Ж.Гантулга/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

ЦИДЭРБАТ

